

**СҮХБААТАР АЙМГИЙН ХАЛЗАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ 02 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

НЭГ. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД

а/ Сумын ИТХ-ын ажлын чиглэлээр: Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албанаас зохион байгуулсан байгууллагуудын хамтын үйл ажиллагааг сайжруулах, мэдээ мэдээлэлээ ил тод шуурхай солилцох ажлын хүрээнд сар бүрийн ажлын эхний өдөр “УДИРДАХ АЖИЛТНЫ МЭДЭЭЛЛИЙН ЦАГ”-аар сумын нийт албан байгууллагуудын дарга эрхлэгч нартай уулзан мэдээлэл солилцон хамтран ажиллаж байна.

2020 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн ИТХ-ын тэргүүлэгчдийн ээлжит хуралдаанаар ЗДТГ-ын хамтын үйл ажиллагааг сайжруулах, ажил үйлчилгээг иргэдэд нээлттэй ил тод хүргэх зарчмын хүрээнд ЗДТГ-ын мэргэжилтэн, албан хаагч нарын 2020 оны ажлын тайлан, цаашдын зорилтын талаар тэргүүлэгчдийн хуралдаанаар нээлттэй сонслоо.

ИТХ-ын тэргүүлэгчдийн ээлжит хуралдаан болж хуралдаанаар 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн нутаг дэвсгэрийн хэсгийн хороог байгуулсан. Мөн Сахиулын 2-р багийг Сайн шандны 3 дугаар багаас салгаж нэг хэсэг байгуулах талаарх хүсэлтийг сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэн ажилласан.

Малын тоо толгойн албан татварын хэм хэмжээг тогтоох эрх зүйн актыг Хууль зүйн яаманд хянуулж 2021 оны 01-29 ны өдрөөс эхлэн энэхүү журмыг дагаж мөрдөхөөр боллоо.

б/ Тамгын газар төрийн удирдлагын ажлын чиглэлээр:

2021 оны 02 дугаар сарын 08 ний өдөр Засаг даргын зөвлөлийн хурлыг хуралдууллаа. Хурлаар: 1.Аймгийн аварга малчны болзол хангасан малчдад шагнал гардуулах 2. Сумын аварга малчдыг хэлэлцэн шийдвэрлэх 3. Сумын аварга малчин шалгаруулах журмыг шинэчлэх, 4. Сумын алдарт уяач шалгаруулах зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв.

Аймгийн аварга малчин -2, сумын аварга малчин-8, Мянгат малчин -7, сумын алдарт уяач -7 тодорч шагнал гардуулах ажлыг 2021 оны 02 дугаар сарын 10-12 ны өдрүүдэд зохион байгуулж ажиллав.

Сар шинийн баярын өдрүүдээр сумын нэгдсэн эргүүлд 24 авто машин 48 албан хаагч 4 чиглэлд хөдөлгөөнт эргүүл постонд ажилласан.

Сумын Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 28 ны өдрийн А/13 тоот захирамжаар байгуулагдсан 12 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 01 дүгээр сарын 28-наас 02 дугаар сарын 10 ны өдрүүдэд цэргийн шинэчилсэн бүртгэлийн зохион байгуулж нийт 481 цэргийн насны иргэдийг бүртгэн ажиллав.

ХОЁР. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД: Энэ сард татварын орлогоор 3471,7 мянган төгрөг, аймгаас авах санхүүгийн дэмжлэгээр 27544,2 мянган

төгрөг авч нийт орлого 31015,9 мянган төгрөг төвлөрсөн байна. Мал хамгаалах санд өвсний үнэ 5264,0 мянган төгрөг төвлөрсөн. Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагуудын хувьд:

- ЕБС 50518,9 мян/төг
- СӨБ 25678,2 мян/төг
- ЭМТ 32960,2 мян/төг

Санхүүжилт авч цалин болон гүйлгээнүүдээ хийж байна. Энэ сард Сүхбаатар суманд ОНХС-ийн талаар 4 сумын бүсийн сургалт болж, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн, ня-бо нар оролцсон. Сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд гаргаж, аймгийн Төрийн аудитын газарт аудит хийлгэхээр хүргүүлж ажиллалаа.

ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН АЖЛЫН ХҮРЭЭНД: малын тоо толгойн албан татвар, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 100 дугаар журмаар сургалт зохион байгуулж ажиллалаа. Сургалтад нийт 5 байгууллагын 25 албан хаагч хамрагдав. 2021 оны 02 дугаар сарын 23, 24 ны өдрүүдэд аймгийн ЗДТГ-т Удаирдах ажилтны зөвлөгөөнд хамрагдлаа.

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

ЕБС: Сар шинийн баярын өдрүүдийг тохиолдуулан байгууллагын багш ажилчид 2-р сарын 10-2 сарын 14-ныг хүртэлх хугацаанд хариуцлагатай жижүүрийг үүрэг гүйцэтгэсэн.

Аймгийн засаг даргын захирамж, БСУГ-ын даргын тушаалаар 2-р сарын 17-ны өдрөөс эхлэн 1,2,5,9-р ангиудад давтлага эхэлсэн.

Хүүхдийг болзошгүй осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр НТБН-ийн багштай хамтран “Хүүхэд хамгааллыг чиглэлээр” цахим хичээл бэлтгэн сум сургуулийн хаяг болон ангийн группүүдэд байршуулсан. Үүний үр дүнд эцэг эхчүүд болон сурагчдын эрх зүйн мэдлэг дээшилсэн. Эрсдлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах талаар мэдлэгтэй болсон. Сурагчдыг ахуйн осол гэмтэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор шторк, боршур бэлтгэн сурагчдад тараасан.

Баруун- Урт сумын 3-р сургуулийн захиргаатай хамтран “Азийн сан, Канадын засгийн газрын санхүүжилтээр” эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 5 сурагчдад ахуйн хэрэглээний зүйлс, эд материалын дэмжлэг үзүүлсэн. Нэг сурагчдад – 50000х5

Цэцэрлэг: Бүлгийн багш нар үзүүлэн тараах материалдаа ашиглан 3, 3 ш эсгий олбог, Ёс заншилын өргөөнд 3 жижүүр газрын зурагтай самбар эсгий хавтангаар, Бүлгийн багш нар эсгийгээр ханын самбар хийж бүлгээ тус тус тохижууллаа. Туслах багш, тогооч, нярав нар өөрсдийн булантай болсон. \Эсгий\ Мөн 4 бүлэгт 1080000 төгрөгний хөшиг авч тохижилт хийлээ.

Багш нар теле хичээлийн конспектоо, ажилчид сарын ажлын төлөвлөгөөгөө батлуулж эрхлэгчид дүгнүүлсэн. Багш Г.Булганлхагва “Цахим хичээл бэлтгэх арга зүй” сэдэвт

сургалт, 2 тогооч эрүүл хооллолтоор, Туслах багш нар хувцас эвхэх, тайлах дарааллаар цахим хичээл тус тус заалаа.

Туслах багш нар их цэвэрлэгээ хийж, гудас ширдгээ гадаа гаргаж ариутгалаа.

Эрхлэгч жижүүр нар Мөнххаан сумын цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцаж туршлага солилцсон.

Мал эмнэлэг: Мал эмнэлгийн газрын цахим хурал 2 удаа зохион байгуулагдаж мал эмнэлэг тасгийн 2 мэргэжилтэн хамрагдлаа.

Мал эмнэлгийн тасгийн Дархвар зүйч мэргэжилтэн шинээр томилогдон ажиллаж байна.

Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг ИТХ-ын тэргүүлэгч нараар оруулах санал хүргүүлсэн .

Хөдөө аж ахуй: Сумын нөөцийн өвсийг малчдад зохих журмын дагуу олгож ажиллав. Сум хөгжүүлэх сангийн зээлдэгч нартай уулзаж монгол банкны хар жагсаалтын талаар мэдээлэл өгч ажиллав. Мал хорогдлын мэдээг цаг тухай бүрт нь холбогдох газарт хүргүүлэн ажиллав.

Байгаль орчны чиглэлээр: Сар шинийн баяр болсонтой холбогдуулан 50 өрхийн 30 тонн хогийг нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлж ажиллалаа. Албан байгууллага, аж ахуй нэгж орчны цэвэрлэгээг зохион байгуулж ажиллалаа. Үүнд 5 албан байгууллагын 87 албан хаагч хамрагдав.

Сумын төвийн айл өрхийн ундны усны тооцоог гаргаж дөрвөлж ОНӨҮГ-т хүргүүллээ

ХЯНАСАН: ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА:
МЭДЭЭ НЭГТГЭСЭН: ХШҮ-ДОТООД АЖИЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

М.БАТБЭХ
Д.ДАЙРИЙМАА